**НИЙСЛЭЛИЙН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2021 оны 02 сарын 05 өдөр Дугаар 08 Улаанбаатар хот

Нийслэлийн өмчид 7 барилга байгууламж
бүртгэн авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01/264 дүгээр албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалт, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл болон "Гүүд Нейборс" Олон Улсын байгууллагын хандив, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Чингэлтэй, Хан-Уул, Багануур дүүргийн нутаг дэвсгэрт тус тус баригдаж ашиглалтад орсон нийт 8,681,233,454.31 /найман тэрбум зургаан зуун наян нэгэн сая хоёр зуун гучин гурван мянга дөрвөн зуун тавин дөрвөн төгрөг гучин нэгэн мөнгө/ төгрөгийн өртөг бүхий 7 барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Д.Сумъяабазар/-д зөвшөөрсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямба/-д даалгасугай.

ДАРГА Ж.БАТБАЯСГАЛАН

1110100013

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 02 дугаар сарын 05-ны
өдрийн 08 дугаар тогтоолын хавсралт

## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ 7 БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

| № | Барилга байгууламжийн нэр | Байршил | Ашиглалтад орсон он | Бүртгэх үнэ /төгрөгөөр/ | Хөрөнгө оруулалтын эх үүсвэр |
|---|---|---|---|---|---|
| 1 | 33 дугаар цэцэрлэгийн барилга байгууламж | Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Худалдааны гудамж | 2020 | 1,990,195,880 | Улсын төсвийн хөрөнгө оруулалт |
| 2 | 280 дугаар цэцэрлэгийн барилга байгууламж | Чингэлтэй дүүрэг, 18 дугаар хороо, Яргаат 34 гудамж | 2020 | 4,476,136,362.31 | Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл |
| 3 | Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн давхарын өргөтгөл | Хан-Уул дүүрэг, 4 дүгээр хороо, Арцатын аманд | 2020 | 650,000,000 | "Гүүд Нейборс" Олон Улсын төрийн бус байгууллагын хандив |
| 4 | Гүн галуутай цогцолбор сургуулийн спорт заалын барилга | Багануур дүүрэг, 1 дүгээр хороо, Наран хороолол | 2020 | 828,570,868 | Улсын төсвийн хөрөнгө оруулалт |
| 5 | Хог ангилах төвийн барилга | Багануур дүүрэг, 3 дугаар хороо, Үйлдвэр хэсэг | 2019 | 637,344,281 | |
| 6 | Зөөврийн ус түгээх байр | Багануур дүүрэг, 4 дүгээр хороо, Тогос уул хэсэг | 2020 | 49,494,664 | Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө |
| 7 | Зөөврийн ус түгээх байр | Багануур дүүрэг, 5 дугаар хороо, Наран хэсэг | 2020 | 49,491,399 | |
| **НИЙТ ДҮН** | | | | **8,681,233,454.31** | |